


МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ  
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,  
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН  
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



# МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САР)

## ГАДААД ХУДАЛДАА (2024 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр)



### Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт:**  
Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр **2,260.9** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн

үеэс 21.9 хувь буюу **495.2** сая ам.доллараар өссөн, гадаад худалдааны тэнцэл **388.9** сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 1 сар				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	1,098.7	1,096.1	1,765.7	2,260.9	495.2	28.0%
-Экспорт	639.8	539.6	1,077.7	1,324.9	247.2	22.9%
-Импорт	458.8	556.5	688.0	936.0	248.0	36.0%
Тэнцэл	181.0	-16.9	389.7	388.9	-0.8	-0.2%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** 2024 оны 01 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл **388.9** сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 495.2 сая ам.доллараар өсөхөд импорт 248.0 сая ам.доллараар өсч, экспорт 247.2 сая ам.доллараар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

**Экспорт:** Экспортын худалдаа 2024 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр **1,324.9** сая ам.долларт хүрч, өнгөрсөн

оны мөн үетэй харьцуулахад **247.2** сая ам.доллар буюу **22.9** хувиар өссөн. Монгол улс дэлхийн 44 оронд бараа экспортлосноос БНХАУ-д 90.4 хувь, Швейцар-т 6.2 хувь, ОХУ-д 1.1 хувь тус тус ногдож нийт экспортын 97.7 хувийг дээрх орнууд эзэлж байна.

**Импорт:** 2024 оны 01 дүгээр сарын байдлаар импортын хэмжээ **1248.0** сая ам.доллараар буюу **36.0** хувиар өссөн байна.

### Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **88.0** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **12.0** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **1,165.8**

сая ам.долларт хүрч, өмнөх оноос **290.2** сая ам.доллар буюу **33.1** хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **159.1** сая ам.долларт хүрч, өмнөх оноос **43.0** сая ам.доллар буюу **21.3** хувиар өссөн байна.

**Хүснэгт 2.** Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 1 сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	562.7	342.4	875.6	1,165.80	290.2	33.1	88.0
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	77.2	197.2	202.1	159.1	-43	-21.3	12.0
Нийт экспорт	639.9	539.6	1,077.70	1,324.90	247.2	22.9	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

### ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 60.6 хувийг нүүрс, 16.6 хувийг зэсийн баяжмал, 3.6 хувийг төмрийн хүдэр ба баяжмал, 2.0 хувийг

боловсруулаагүй нефть эзэлсэн байна.

**Хүснэгт 3.** Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Эхний 1 сар				Өмнөх оны мөн үеэс	
		2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	109.6	81.0	110.6	124.1	13.5	12.2
Нүүрс	сая.тн	2.5	0.6	3.5	6.6	3.1	88.6
Төмрийн хүдэр	сая.тн	0.6	0.0	0.4	0.6	0.2	66.7
Цайрын баяжмал	мян.тн	11.8	3.3	20.2	5.8	-14.4	-71.3
Алт	тн	-	2.5	2.0	0.3	-1.7	-85.0
Боловсруулаагүй нефть	сая.баррель	0.5	-	0.4	0.4	-	-
Катодын зэс	тн	9.6	0.2	0.1	0.4	0.3	300.0
Жоншны баяжмал	мян.тн	74.3	13.2	54.7	105.1	50.4	92.1
Адууны мах	мян.тн	2.3	-	3.8	1.9	-1.9	-50.0
Өлөн гэдэс	тн	21.8	1.9	1.5	69.5	68.0	4,533.3

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	-	0.1	0.4	0.8	0.4	100.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	22.3	-	8.4	39.0	30.6	364.3
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	0.0	-	-	0.8	0.8	800.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	10.3	6.6	5.4	2.0	(3.4)	(63.0)
Самнасан ноолуур	тн	11.3	52.6	6.0	95.9	89.9	1,498.3
Бохир ноолуур	тн	187.0	642.6	47.2	35.4	(11.8)	(25.0)
Хонины самнаагүй ноос	мян.тн	0.8	-	-	0.7	0.7	700.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

#### Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	Эхний 1 сар				Өмнөх оны мөн үеэс	
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	194.3	194.3	183.6	220.2	36.6	19.9
Нүүрс	220.7	220.7	565.3	803.1	237.8	42.1
Төмрийн хүдэр	73.1	73.1	25.9	47.4	21.5	83.0
Цайрын баяжмал	17.7	17.7	30.8	7.8	-23.0	-74.7
Алт	-	-	121.8	20.8	-101.0	-82.9
Боловсруулаагүй нефть	25.5	25.5	29.5	27.1	-2.4	-8.1
Катодын зэс	59.3	59.3	0.6	2.8	2.2	366.7
Жоншны баяжмал	15.9	15.9	14.2	22.5	8.3	58.5
Адууны мах	4.7	4.7	11.3	6.7	-4.6	-40.7
Өлөн гэдэс	0.5	0.5	0.1	1.2	1.1	1,100.0
Үхэр, адууны боловсруулсан шир	-	-	0.1	0.0	-0.1	-70.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.0	0.0	-	0.1	0.1	100.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.0	0.0	-	0.0	-	-
Ямаа, ишигний боловсруулсан арьс	0.4	0.4	0.1	0.0	-0.1	-60.0
Самнасан ноолуур	0.7	0.7	0.7	9.8	9.1	1,300.0
Бохир ноолуур	6.1	6.1	2.6	1.6	-1.0	-38.5
Хонины самнаагүй ноос	0.8	0.8	-	0.7	0.7	700.0
<b>Нийт экспортод эзлэх хувь</b>	<b>96.8</b>	<b>96.8</b>	<b>91.6</b>	<b>88.5</b>		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

## Эрдсийн бүтээгдэхүүний экспортод голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

**1. Нүүрс:** 2024 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр **6.6** сая тонн нүүрс экспортолж, **803.1** сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ **3.1** сая тонноор өссөн бол экспортын орлого мөн **237.8** сая ам.доллараар буюу **42.1** хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын хэмжээ **88.6** хувиар өссөн нь нүүрсний экспортоос олох орлого нэмэгдсэн байна. Нэг тонн нүүрсний 2024 оны дундаж үнэ 32.9-208.2 ам.доллар байсан бөгөөд чулуун нүүрсийг 100.0 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**2.Зэсийн баяжмал:** 2024 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс **19.9** хувь буюу **36.6** сая ам.доллараар өсөж, **202.2** сая ам.доллар болсон байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ **124.1** мянган тонн болж, өнгөрсөн оны мөн үеэс **12.2** хувь буюу **13.5** мянган тонноор өссөн. Нэг тонн зэсийн баяжмалын 2024 оны дундаж үнэ 8,393.6 ам.доллар бөгөөд зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**3.Нефть:** 2024 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр боловсруулаагүй нефтийн экспортын тоо хэмжээ **0.4** тонн болж, **27.1** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Экспортын тоо хэмжээний хувьд ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна.

**4.Төмрийн хүдэр:** 2024 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ **0.6** сая тонн болж, **47.4** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс **83.0** хувь буюу **21.5** сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ **66.7** хувь буюу **0.2** сая тонноор өссөн. Экспортын биет хэмжээний өсөлт тус бүтээгдэхүүнээс олох өсөхөд нөлөөлсөн байна. Нэг тонн төмрийн хүдрийн 2024 оны дундаж үнэ 104.4-119.3 ам.доллар байсан.

**Алт:** 2024 оны 01 дүгээр сарын гүйцэтгэлээр алтны экспортын тоо хэмжээ **0.3** тоннд хүрч, 20.8 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өмнөх 2020, 2021 оны мөн үед алт экспортоолоогүй байна. Нэг тонн алтны 2024 оны дундаж үнэ 223,029.8 ам.доллар байсан.

## Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Манай улс дэлхийн 113 орноос гарал үүсэлтэй бараа импортлосноос БНХАУ-д 38.7 хувь; ОХУ-д 26.0 хувь; Япон-д 13.3 хувь; БНСУ-д 3.4 хувь; АНУ-д 2.5 хувь тус тус ногдож байгаа нь нийт импортын дүнгийн 84.0 хувийг эзэлж байна.

Нийт импортын **26.2** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **73.8** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Импортоор нийт 936.0 сая ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь 2023 оны мөн үеэс 248.0 сая ам.доллараар буюу 36.0 хувиар өссөн байна.



**Хүснэгт 5. Эрдсийн бүтээгдэхүүний импорт**

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний 1 сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2021	2022	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	96.2	131.6	180.2	221.9	41.7	23.1	23.7
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	362.6	424.9	507.8	714.0	206.2	40.6	76.3
<b>Нийт импорт</b>	<b>458.8</b>	<b>556.5</b>	<b>688.0</b>	<b>936.0</b>	<b>248.0</b>	<b>36.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд авто, агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд ангийн импорт 26.6 хувь, эрдэс бүтээгдэхүүний импорт 23.7 хувь, машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэгийн импорт 18.2 хувь, хүнсний зүйлийн импорт 7.5 хувь, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 5.9 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 6. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр**

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Бүтэц (хувиар)
		2023.01	2024.01	Сая.ам доллар	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	9.6	10.9	1.3	13.5	1.2
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	8.7	18.6	9.9	113.8	2.0
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	4.9	4.0	-0.9	-18.4	0.4
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	54.6	70.1	15.5	28.4	7.5
5	Эрдэс бүтээгдэхүүн	180.2	221.9	41.7	23.1	23.7
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	37.3	40.9	3.6	9.7	4.4
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	28.5	25.3	-3.2	-11.2	2.7
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	0.7	0.6	-0.1	-14.3	0.1
9	Мод, модон эдлэл	4.4	6.4	2	45.5	0.7
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	6.6	7.1	0.5	7.6	0.8
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	10.4	11.0	0.6	5.8	1.2
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	2.5	3.0	0.5	20.0	0.3
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	17.8	17.8	0	0.0	1.9
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	0.2	0.3	0.1	50.0	0.0
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	47.3	55.0	7.7	16.3	5.9
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	104.5	170.5	66	63.2	18.2
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	144.2	249.0	104.8	72.7	26.6
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	11.0	11.7	0.7	6.4	1.3
19	Зэвсэг, галт хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	14.3	0.1	-14.2	-99.3	0.0
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	0.0	12.0	12	0.0	1.3
21	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.2	-	-0.2	-100.0	0.0
	<b>ДҮН</b>	<b>688.0</b>	<b>936.0</b>	<b>248.0</b>	<b>36.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

## Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага 2024 оны 01 дүгээр сард Улсын төсөвт **503.1** тэрбум төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэйгөөс **534.8**

тэрбум төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө **106.3** хувийн гүйцэтгэлтэй байна.

### Хүснэгт 7. Орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний 1 сар				
	2020	2021	2022	2023	2024
Төлөвлөгөө	247.7	264.4	292.7	401.9	503.1
Гүйцэтгэл	232.7	238.6	298.1	403.7	534.8
Хувь	93.9%	90.2%	101.8%	100.4%	106.3%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

## Тав. Татварын чөлөөлөлт

2024 оны 01 дүгээр сарын байдлаар нийт импортод татвартай импорт **96.8** хувь, татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээрээ **3.1** хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 1,033.74 тэрбум төгрөгөөр буюу 54.7 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн импорт 88.2 тэрбум төгрөгөөр буюу

48.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 8. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний 1 сар				
	2020	2021	2022	2023	2024
Татвартай импорт	1,117.8	1,162.0	1,490.9	1,890.4	2,924.1
Эзлэх хувь	86.5%	89.0%	97.1%	91.2%	96.9%
Татвараас чөлөөлөгдсөн	174.8	143.8	44.0	182.4	94.2
Эзлэх хувь	13.5%	11.0%	2.9%	8.8%	3.1%
<b>Нийт импорт</b>	<b>1,292.6</b>	<b>1,305.8</b>	<b>1,534.9</b>	<b>2,072.7</b>	<b>3,018.3</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын татвараас чөлөөлөгдсөн **94.2** тэрбум төгрөгийн бараанд 2024 оны 1 дүгээр сард ногдуулвал зохих **36.3** тэрбум төгрөгийн татвар холбогдох хууль тогтоомжийн дагуу татвараас чөлөөлөгдсөн байна. Үүнд:

1. Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг 0.03 тэрбум төгрөг;
2. ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис 0.2 тэрбум төгрөг;
3. Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж 0.9 тэрбум төгрөг;
4. Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг 1.7 тэрбум төгрөг;
5. Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл 2.41 тэрбум төгрөг;

6. Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ 5.8 тэрбум тэрбум төгрөг,
7. Бусад татварын хуулийн зүйл заалтуудаар 22.7 тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

#### ТАТВАРЫН ХОЙШЛУУЛАЛТ

Засгийн газрын 2022 оны 335 дугаар тогтоолыг хэрэгжүүлж Шивээхүрэн боомтын чингэлэг тээврийн терминалын төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Эрчим хүчний сайд, “Шивээхүрэн терминал” ХХК, “Нарийн сухайт эрчим” ХХК-ийн хооронд 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр 25/Г-27/2033/012-23/А/2023-13/ тоот гэрээ хийгдэж Нарийн сухайт ХХК нь гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжөөс **9.5** тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий тоног төхөөрөмжийг импортолж **1.5** тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан 2023 оны 5 дугаар сарын 22-ноос эхлэн гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.

Засгийн газрын 2015 оны 190 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж Цагаан суваргын зэс, молибдений баяжуулах үйлдвэр төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Уул уурхайн сайд, “Монголын алт” ХХК, “Эрдэнэс цагаан суврага” ХХК-ийн хооронд 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдөр 41,20,195-2323/0012-5123 тоот гэрээний дагуу Эрдэнэс цагаан суврага ХХК нь гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжийн үнийн дүнд ногдуулсан 17.6 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан 2023 оны 5-р сарын 22-ноос эхлэн гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.

#### ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ

Засгийн газрын 2023/06/21-ний өдрийн Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 244 дүгээр тогтоолоор дизелийн түлшний Онцгой албан татварыг 2025-01-01 хүртэл “0” хувь хэмжээгээр тогтоосон. /Засгийн газрын 2022/12/28-ны өдрийн Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 496 дугаар тогтоолын дагуу 2023-07-01 хүртэлх хугацааг сунгасан./ Ингэснээр 2024 оны 01 сарын байдлаар нийт 129.9 мянган тонн дизелд ногдуулах 29.1 тэрбум төгрөгийн онцгой албан татварыг хөнгөлсөн.

Засгийн газрын 2023/01/25-ны өдрийн Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай 85 дугаар тогтоолоор импортоор оруулж ирсэн 92 октантай автобензиний гаалийн тарифыг “0” хувиар тогтоосон. Ингэснээр 2024 оны эхний 01 сарын гүйцэтгэлээр нийт 82.6 мянган тонн бүхий бараанд 10.3 тэрбум төгрөгийн татварыг хөнгөлсөн.

Гаалийн байгууллага нь Улсын төсөвт нийт 534.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн ч холбогдох хууль тогтоожийн дагуу ногдуулвал зохих 75.7 тэрбум төгрөгийн татварыг чөлөөлж, хөнгөлсөн.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



